# Сэдэв: Үзүүлэн бэлтэх программ ашиглах

Н.Мөнх-Оргил

# Ерөнхий танилцуулга

- ***Судалгаат хичээлийг явуулах үндэс:*** Хичээлийн судалгааны арга зүйг хөгжүүлэх

# Хичээлийн санаа

Энэхүү хичээлийн сэдэв нь үзүүлэн бэлтгэх програм ашиглах байсан бөгөөд MS word програмìтай ижил office багц програмын нэг болох MS powerpoint програмì дээр шинэ слайд оруулах текст байрлуулах, зураг, дуу, бичлэг оруулах зэргийг MS Word програмìтай харьцуулан хийлгэх зорѐлго тавьсан.

- Хичээлийн бэлтгэл судалгааг Шилүүстэй сумын бүрэн дунд сургуулийн мэдээлэл зүйн багш Н.Мөнх-Оргил, биеийн тамирын багш Ч.Батбаяр, нийгмийн ажилтан Ж.Отгон-Өлзий нар хамтран бэлтгэсэн. 2012 оны намрын мониторингийн үеэр багш Н.Мөнх-Оргил заасан.

## Дутагдал

- Энэ хичээлийн сэдэлжүүлэх хэсэгт архи тамхины эсрэг сурталчилгааны цаасан үзүүлэн бэлтгэх даалгавар төлөвлөгдсөн энэ нь маш их цаг хугацаа авч мөн цаасан үзүүлэн хийх материал тутмаг байсан учир сурагчид яаж хийхээ мэдэхгүй цаг их алдсан.

## Хэрхэн сайжруулсан

- Хүүхдүүд цаасан үзүүлэн хийхэд хугацаа их авж байсан учираас баг бүрт ижилхэн 5 ширхэг зураг мөн хэмжээний текст бэлнээр тарааж өгөх сурагчид тэдгээрийг ватум цаасан дээр нааж байрлуулах болгож сайжруулсан.

| Дутагдал | Хэрхэн сайжруулсан |
| --- | --- |
| Мөн мэдлэг бүтээх хэсэгт MS powerpoint програмìын тухай ойлголтгүй хүүхдүүд шууд ажиллахад хүндрэлтэй байсан. | - **Шинэ слайд нээх, slide show хийх зэрэг word програм дээр байдаггүй зүйллийг цаасан зөвлөмжөөр тарааж өгөхөөр хөтөлбөрөө сайжруулсан.** |

| Дутагдал | Хэрхэн сайжруулсан |
| --- | --- |
| Хичээлийн төгсгөл нь их муу уналттай болсон | Хичээлийн төгсгөлд Д.Нацагдоржийн Жаргалан шүлгийн хэсгээс уншиж хичээлээ дуусгахаар хөтөлбөрөө сайжруулсан. |

# Хичээлийн эхлэл хэсгийн шийдэл

- Сурагчид 5 хүүхдийн бүрэлдэхүүнтэй 4 баг болж суусан. Хичээл эхлэхэд сурагчдаар архи тамхины хор уршигийн талаар зүйр үг хэлүүлж эндээс тэр хортой зүйлийн эсрэг үзүүлэн хийе гэсэн уриалага гаргасан.
-

- Сурагчдыг цаасан үзүүлэнгээ хийгээд дуусах үед энэ хийсэн үзүүлэнгээ компьютер дээр хийе гэж асуудал дэвшүүлсэн гэхдээ өөрсдийн мэддэг word программ дээр биш powerpoint программ дээр хийхийг санал болгоод хичээлийн сэдэв, зорилго зорилтоо танилцуулсан.

# Хичээлийн өрнөл хэсэг

- Хичээлийн мэдлэг бүтээх хэсгийг бүхэлд нь сурагчдад үлдээсэн. Багшийн зүгээс тусламж хэрэгтэй болсон тохиолдолд очиж туслах үүрэг гүйцэтгэсэн. Мөн мэдлэг бүтээх болгонд нэмэлт мэдээлэл тарааж өгч үнэлсэн

# Хичээлийн төгсгөл хэсэг

- Сурагчдын хийсэн илтгэлийг баг болгоноос танилцуулсан энэ үед сурагчдаас илтгэл бэлтгэхэд шаардагдаж байсан мэдлэгийг асууж хичээлээ нэгтгэн дүгнэсэн. Тэгээд Д.Нацагдорж жаргалан шүгийн хэсгээс уншаад гэрийн даалгавараа өгсөн.

# Дүгнэлт

- Энэ хичээлийн гол санаа өгөх зүйл нь сурагчид өмнө нь MS word програм дээр чөлөөтэй ажиллаж чаддаг powerpoint програмын цэс нь ижил учраас сурагчид бүх зүйлийг өөрөө хийж сурч байсан нь юм. Нэг үгээр хэлэхэд сурагчийн үйл ажиллагаа гололсон хичээл болсон. Мөн энэ хичээл нь хичээл хоорондын залгамж холбоо сайтай хичээл болсон гэж үзэж байгаа.

# Анхаарч сонссонд баярллаа